3.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар хүсэлтийн дагуу гэрээний хугацааг хоёр тал хамтран тохиролцсоны үндсэн дээр сунгах;

Дөрөв. Захиалагчийн эрх

4.1. Захиалагч орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дахин эксперт томилуулах санал оруулах;

4.2. Томилогдсон тухайн эксперт магадлалын ажлыг гүйцэтгэх боломжгүй бол ажлын 1 хоногийн дотор мэдэгдэж экспертийг дахин томилуулах;

4.3. Гэрээнд заагдсан хугацаанд ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд хугацааг сунгах, үндэслэлийг гаргах;

Тав. Захиалагчийн үүрэг

5.1. Гэрээний хавсралт бүхий баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

5.2. Магадлалын ажилд шаардагдах хууль эрх зүйн баримт бичиг, материалыг тухай бүр цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;

5.3. Магадлалын дүгнэлтээр гарсан зарчмын санал, зөрчлийг барилга байгууламжийн зураг төслийг хянан нягталж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд багтаан залруулга, тодруулга тайлбарыг хийж гүйцэтгэсэн байх;

5.4. Энэхүү гэрээний 1.4-д заасан хугацаатай уялдуулан орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийн дагуу залруулга /засвар/-ыг 10 хоногт[1] багтаан хийж дуусган тус төвийн гэрээ хийсэн мэргэжилтэнд хүргүүлсэн байх;

Зургаа. Хүлээх хариуцлага

6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ;

6.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар гэрээ сунгавал тухай бүр тэмдэглэл хөтөлж, гэрээний биелэлтийг дүгнэж сунгах эсэх асуудлыг шийдвэрлэж байна.

6.3. Зураг төсөл магадлалын ажил гүйцэтгэх явцад энэхүү гэрээний 5.4-т заасан хугацааг хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төслийн магадлалын ажлын төлбөрийн дүнгийн 0.4 хувиар алдангийг тооцно.

6.4. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх хугацаанд байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн нөхцөлд зайлшгүй нотлох баримтыг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.5. Энэхүү гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь “Монгол хэл” байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтсийн дарга
..... /Э.ХАНГАЛ/

Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтсийн мэргэжилтэн
..... /П.МӨНГӨНТУУЛ/

Утас: 70115255

Захиалагчийг төлөөлж:

"Би эс консалтинг" ХХК
менежер
..... /Б.МӨНХЦЭЦЭГ/

Захиалагчийн утас:99841803
Гүйцэтгэгчийн утас:99116139

[1] *Хугацааг хуанлийн өдрөөр тооцно.*